



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 324

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Харгуй” Төрийн өмчит хувьцаат компанийн 2018 он, 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж 78,1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Харгуй” Төрийн өмчит хувьцаат компанийн 2018 он, 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний талаар төлөвлөгөөт ажил зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэхийг “Харгуй” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.

3. “Харгуй” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захидал Н.Болдбаатарт дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллан санхүүгийн сахилга батыг тогтоох;

3.2. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох талаар санал боловсруулан танилцуулж байх;

3.3. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллах үргээ хангальтгүй биелүүлсэн, алдаа дутагдал гаргасан албан тушаалтан нарт хариуцлага тооцох;

3.4. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

3.МЭНДСАЙХАН

Ц. ТҮВШИНЗАЯА

000589

Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06 -ний өдрийн
32/дугаар тогтоолын хавсралт

“Харгүй” Төрийн Өмчийт хувьцаат компанийн 2018 он, 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх
удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалтгаар илрэсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Зөрчлийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн Өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан худалдан авах тухай захирал, Санхүү, бүртгэлийн хэлтэс дугаар 32/дугаар тогтоолын байдлаарх худалдан авалт хийсэн зөрчил	Гүйцэтгэх захирал, Санхүү, бүртгэлийн хэлтэс	78.1	Төрийн болон орон нутгийн Өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандaa мөрдөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр Нээлттэй ил тод зарлаж, журамын дагуу зохион байгуулж, тогтоосон хугацаанд тайлан гарган хургуулж байх.
	Зөрчил, дутагдлын нийт дүн		78.1	